



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 19


Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн “Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад “Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч С.Мөнхжаргал”, “Тээврийн цагдаагийн албаны Хан-Уул дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Г.Бямбадорж”, “Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга З.Буянт” гэж нэмсүгэй.
2. Тус тогтоолын 1 дүгээр хавсралтын 4 дэх заалт буюу “Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч” гэснийг хассугай.

ДАРГА



Ч.БАТ-ОРГИЛ